




**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
ОЮУНЫ ӨМЧИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО
(2025-2027 он)**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү баримт бичгийн зорилго нь Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн (цаашид "МУБИС" гэх) оюуны өмчийг бүтээх, шилжүүлэх, ашиглах, хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах, ашиг хуваарилах, олон нийтийн хүртээл болгох, мэдлэгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, хамтын ажиллагааны таатай нөхцөлийг бүрдүүлэх, оюуны өмч дээр суурилсан судалгааны хөгжлийг дэмжих, оюуны өмчийн соёлыг төлөвшүүлэх, оюуны өмчийн бодлого төлөвлөлт, хэрэгжүүлэх зарчим, удирдлага зохион байгуулалтыг бэхжүүлэх цогц бодлогыг тодорхойлоход оршино.

1.2. МУБИС-ийн оюуны өмчийн талаар баримтлах бодлогын баримт бичиг нь (цаашид "Бодлого" гэх) Монгол улсын нэгдэн орсон Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Патентын тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, Инновацийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, Патентын хамтын ажиллагааны гэрээ, Марракешийн гэрээ, Бернийн конвенц болон олон улсын хэлэлцээрүүд, Дээд боловсролын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.3.7-д "Оюуны бүтээлийн үнэлэмжийг нэмэгдүүлж, шинэ бүтээл, оюуны өмч, судалгаа шинжилгээ, шинэ технологийг эдийн засгийн эргэлтэд оруулж, салбаруудын бүтээмжийг нэмэгдүүлнэ" гэснийг, "МУБИС-ийн стратеги төлөвлөгөө 2025-2030"-г тус тус үндэс болгоно.

1.3. Энэхүү бодлого нь МУБИС-ийн багш, ажилтан, зочин судлаач, суралцагчид болон тэдний бүтээсэн аливаа оюуны өмчид хамаарна.

ХОЁР. БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

2.1. Бодлого нь хэтийн хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, шинэ мэдлэг, шинэ буюу сайжруулсан боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцыг нэвтрүүлэх тэдгээрт суурилсан оюуны өмч, технологи, инновац бүтээх, гарааны компанийн үйл ажиллагааны чиглэлийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах хамтын үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах эрхзүйн таатай орчин бүрдүүлэх олон улсын жишигт нийцсэн их сургууль болоход чиглэгдэнэ.

ГУРАВ. БОДЛОГЫН ЧИГЛЭЛ, ЗАРЧИМ

3.1. Бодлогын чиглэл

3.1.1. МУБИС нь өөрийн оюуны өмчийг бий болгох багш, ажилтан, зочин судлаач, тэнхим, бусад нэгжид санхүүгийн, техникийн, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх;

3.1.2. Бодлого нь МУБИС-ийн Стратеги төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг хангахад чиглэх;

3.1.3. Бодлогын хэрэгжилтийг хангах эрх зүйн актууд боловсруулан мөрдлөг болгох;

3.1.4. Оюуны өмчийн харилцаанд оролцогч талуудын бизнесийн хамтын ажиллагаа, гадаад, дотоод түншлэлийг дэмжих;

3.1.5. Багш, ажилтан, суралцагч, зочин судлаачидтай байгуулдаг хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод энэхүү бодлогын заалтуудыг оруулах;

3.1.6. Оюуны өмчийг бүтээх, ашиглах, хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах, цогц тогтолцоог бий болгож, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлж, хамтын ажиллагааны таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.7. Суралцагчдад оюуны өмчийн мэдлэг олгох, суралцагчдын суралцах чадварыг сайжруулах, асуудлыг шинэ аргаар шийдвэрлэх, боловсролын бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц, түншлэл зэргийг хөгжүүлж, оюуны өмчийн эрхийг авах, эдийн засгийн эргэлтэд оруулах;

3.1.8. Байгууллагын оюуны өмчийн талаарх хариуцсан ажилтны мэдлэгийг дээшлүүлж, хүний нөөцийг бэлтгэх;

3.1.9. Оюуны өмчид хамаарах бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулснаас олох орлогыг гэрээнд заасны дагуу хуваарилах;

3.1.10. Оюуны өмчийн хороо нь оюуны өмч, инновац, технологи дамжуулах түүнийг үнэлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, санхүүжүүлэх, ашиг хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулах;

3.1.11. Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулснаас олох орлогоос хуримтлал үүсгэж, судалгаа хөгжүүлэлт, гарааны бизнес, энтрепренёрийг дэмжих;

3.2. Бодлогыг хэрэгжүүлэх зарчим

3.2.1. МУБИС-ийн багш, ажилтан, зочин судлаач, суралцагчид чиг үүргээ хэрэгжүүлэхдээ энэхүү бодлогыг баримтлах;

3.2.2. Оюуны үнэт зүйл, академик эрх чөлөөг дээдэлсэн оюунлаг, судалгааны чадавхтай, шинэ мэдлэг, технологи, инновацыг санаачлагч, зохион бүтээгч, бүтээлчээр хэрэгжүүлэгч хамт олон бүрдүүлэх;

3.2.3. Оюуны өмчийн бүтээлч сэтгэлгээг бий болгох;

3.2.4. Оюуны өмчийн эдийн болон эдийн бус баялгийн эрхийг хүндэтгэх;

3.2.5. МУБИС үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх үед эсвэл хамтарсан төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болсон оюуны өмчийн эрх эзэмшигчийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тодорхойлох, эрхийг нь хүндэтгэх;

3.2.6. Оюуны өмчийн харилцаанд оролцогч талууд (МУБИС, Оюуны өмчид хамаарах бүтээлийн зохиогч, хамтран зохиогч, эрх эзэмшигч, гуравдагч

этгээд)-ын харилцааг зохицуулахдаа хуулийн дагуу, эрх тэгш, нээлттэй байдал, шударга ёсыг эрхэмлэх;

3.2.7. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, түүнээс сэргийлэх;

ДӨРӨВ. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. Оюуны өмчийн удирдлагын эрх зүйн орчин бүрдүүлэхэд энэхүү бодлогыг үндэс болгоно.

4.2. МУБИС-ийн оюуны өмчийн удирдлага, зохион байгуулалт хариуцсан "Оюуны Өмчийн Хороо" эрдмийн зөвлөлийн дэргэд ажиллана. Гишүүдийн саналаар даргыг сонгоно.

4.3. МУБИС-ийн Оюуны өмчийн талаар баримтлах бодлого, холбогдох журмуудын хэрэгжилтэд чанарын баталгаажуулалт, мониторинг хариуцсан нэгж үнэлгээ хийнэ.

4.4. Хорооны дарга, гишүүдийн эрх, үүргийг МУБИС-ийн "Оюуны өмчийг бүртгэх, хадгалах, ашиглах, эзэмших журам"-аар зохицуулна.

4.5. Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгж оюуны өмч, инновац, технологи дамжуулах түүнийг үнэлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, санхүүжүүлэх, ашиг хуваарилах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.6. Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгж МУБИС-ийн оюуны өмчийг "Удирдлага мэдээллийн сан"-д бүртгэж, хадгалах, хамгаалах, асуудлыг хариуцна.

4.7. Оюуны өмчийн хороо нь оюуны өмчийн бодлогын хүрээнд гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжилтэн, шинжээч, зөвлөхүүдтэй хамтран ажиллаж болно.

4.8. Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгж, оюуны өмчийн хороо нь бодлогын баримт бичгийг шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Эрдмийн Зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулна.

ТАВ. ОЮУНЫ ӨМЧ

5.1. МУБИС-ийн багш, ажилтан, суралцагч, зочин судлаач дотоодын санхүүжилттэй болон сургуулийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын байгууллагатай гэрээ байгуулж хамтран хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, захиалгат ажлуудын оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх, аж үйлдвэрийн өмчид хамаарах бүтээлийг /Шинэ бүтээлийн патент, ашигтай загварын патент, бүтээгдэхүүний загварын патент, барааны тэмдэг, газар зүйн заалт/ МУБИС эзэмшинэ.

5.2. Оюуны өмчийн эзэмших эрхийг "Оюуны өмчийг бүртгэх, ашиглах, эзэмших журам"-ын дагуу зохицуулна.

5.3. МУБИС дараах тохиолдолд бүтээл эзэмших эрх эдэлнэ.

5.3.1. Багш, ажилтан, зочин судлаачид МУБИС-ийн өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээнд¹ ашигласан, албан үүргээ гүйцэтгэх буюу хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад хөгжүүлсэн бүтээлийг;

¹ МУБИС-ийн "Оюуны өмчийг бүртгэх, хадгалах, ашиглах, эзэмших журам"

5.3.2. Суралцагчдын гадаад, дотоод болон МУБИС-ийн санхүүжилттэй судалгааны үр дүнг эсвэл тоног төхөөрөмжийг мэдэгдэхүйц хэмжээгээр ашиглан гүйцэтгэсэн дипломын ажил, эрдэм шинжилгээний бүтээлийг;

ЗУРГАА. ОЮУНЫ ӨМЧИЙН АШГИЙН ЗОХИЦУУЛАЛТ

6.1. Оюуны өмчийн ашиг хуваарилах зарчмыг "Оюуны өмчийг бүртгэх, хадгалах, ашиглах, эзэмших журам"-аар зохицуулна.

6.2. Оюуны өмчийн ашгийг хуваалцахад хамаарахгүй бүтээлүүдэд хичээл, сургалт, өгүүлэл, нэвтрүүлэг зэргийг ойлгоно.

6.3. Зохиогч МУБИС-тай хамтран эзэмшиж буй оюуны өмчийн бүтээлийн орлогоос өөрт ноогдох хувийг хүртэх эрхтэй бөгөөд ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ч хэвээр хадгалагдана.

ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1. Оюуны өмчийг хамтран эзэмшихээр гэрээ байгуулах тохиолдолд (багш, ажилтан, зочин судлаач, гуравдагч этгээдтэй байгуулах гэрээ) талуудын эрх, үүрэг, хариуцлагыг гэрээнд нарийвчлан тодорхойлох ба талуудын аль нэг нь хууль тогтоомж буюу шүүхийн шийдвэрийн дагуу ногдуулах торгууль аливаа шаардлага, нэхэмжлэлээс үүдэх хууль зүйн хариуцлагаас ангид байлгана.

7.2. Энэхүү бодлого болон "Оюуны өмчийг бүртгэх, хадгалах, ашиглах, эзэмших журам"-ын хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд МУБИС-ийн судлаачийн ёс зүйн дүрэмд зааснаар хариуцлага хүлээлгэж, асуудлыг шийдвэрлэнэ.

НАЙМ. БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

8.1. Хэрэгжүүлэх арга зам

8.1.1. Оюуны өмчийн цогц ажиллагаа, харилцааг зохицуулах "Оюуны өмчийг бүртгэх, хадгалах, ашиглах, эзэмших журам"-ыг боловсруулан мөрдлөг болгох;

8.1.2. МУБИС оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг хийж хамтын ажиллагаатай гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагууд, их, дээд сургуулиуд болон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, компаниудад тааламжтай хөрөнгө оруулалтын орчин бий болгож, санхүүгийн болон эрдэм шинжилгээ, инновацын судалгааг дэмжиж ажиллах;

8.1.3. Оюуны өмч, технологи дамжуулах, арилжих эрх зүйн орчин, удирдлага зохион байгуулалт, дэд бүтэц, тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэхийг дэмжих;

8.1.4. МУБИС-ийн оюуны өмчид хамаарах аж үйлдвэрийн өмчийн болон зохиогчийн эрхийн бүтээлийн талаарх аливаа мэдээллийг зохиогч, эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүй нийтэд задлахгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, бүтээлийн ноу-хау, томъёолол, нууцыг хадгалах;

8.1.5. Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулснаас олох орлогыг МУБИС-ийн хөгжлийн дансанд төвлөрүүлж, багш, ажилтан, зочин судлаач, суралцагчдын цаашдын судалгаа-шинжилгээг дэмжиж, эдийн засгийн бодит үр ашгийг дээшлүүлэх;

8.1.6. МУБИС-ийн шаардлагатай сургалт арга зүйн эмхэтгэлүүдэд /мэргэжлийн хөтөлбөр/ зохиогчийн эрхийн гэрчилгээ авч хамгаалуулах;

8.1.7. МУБИС-ийн хичээлийн хөтөлбөрийн дагуу хийгдсэн цахим хичээлд зохиогчийн эрхийн гэрчилгээ авах, хамгаалуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах, ашиг хуваарилахыг "Оюуны өмчийг бүртгэх, хадгалах, ашиглах, эзэмших журам"-аар зохицуулах;

8.1.8. Багш, ажилтан, зочин судлаач, суралцагчид нь өөрийн нэр дээр эзэмшиж буй "Оюуны өмч"-ийг МУБИС-ийн аливаа үйл ажиллагаанд ашиглах зөвшөөрлийн хүсэлтийг Эрдэм шинжилгээний асуудал хариуцсан нэгж, оюуны өмчийн салбар хороо баталгаажуулах ба талууд бичгээр үйлдэж гэрээг байгуулсан байх;

8.1.9. МУБИС-ийн эрдэм шинжилгээ, инновац хариуцсан нэгж дотоодын санхүүжилттэй төслөөр болон МУБИС-тай хамтран эзэмшихээр гэрээ байгуулсан багш, ажилтан, суралцагч, зочин судлаачдын бүтээсэн оюуны өмчийн эрхийн цахим нэгдсэн санг бий болгох;

8.1.10. Оюуны өмчийн сургалтыг эрдэм шинжилгээ, инновац хариуцсан нэгж санаачлан зохион байгуулах;

8.1.11. МУБИС-ийн өмчлөл, хамтран эзэмшигчээр байгаа оюуны өмчийн бүтээл болон бусад зохиогч, эрх эзэмшигч нарын бүтээлийг гэрээний үндсэн дээр эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор хувь хүн, хуулийн этгээдэд худалдах, лицензээр ашиглуулах, өөрөө санхүүжүүлж, дэмжлэг үзүүлснээс олсон бизнес үйл ажиллагааны орлого, ашгийн хуваарилалтыг оруулсан хөрөнгө оруулалт, ажлын гүйцэтгэл, оролцоо, оюуны өмчийн үнэ цэнийг үндэслэн хуваарилах;

8.1.12. Багш өөрийн бүтээлийг МУБИС-тай хамтран эзэмшигчээр оюуны өмчийн эрхийг баталгаажуулж, тус сургуулиас санхүүгийн дэмжлэг авсан тохиолдолд эдийн засгийн эргэлтэд оруулж, ашиг хүртэх;

8.1.13. МУБИС-ийн оюуны өмчийг эрдэм шинжилгээ инновац, гарааны компанийн үйл ажиллагаа болон бусад хэлбэрээр эдийн засгийн эргэлтэд оруулах түүнээс олсон орлого, хуримтлалыг МУБИС-ийн хөгжлийн дансанд байршуулах үйл ажиллагааг зохион байгуулах;

8.1.14. МУБИС-ийн оюуны өмчийн болон гарааны компани байгуулах эдийн засаг, стратеги төлөвлөгөө, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн нууцыг нийтэд ил болгож түгээсэн, задруулсан этгээдэд Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхээр зохих шатны байгууллагад хандах;

8.1.15. Хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд хувийн, эдийн болон эдийн бус ашиг сонирхлоор МУБИС-д хашиж байгаа албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчил гаргасан тохиолдолд Монгол улсын иргэний хууль, Авлигын эсрэг хууль тогтоомж бусад холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхээр зохих шатны байгууллагад хандах;

8.1.16. Энэхүү бодлогыг олон нийтэд нээлттэй байршуулах;

8.2. Үр дүн

8.2.1. МУБИС-ийн нэр дээр бүртгэлтэй оюуны өмчийн эрхийн тоо нэмэгдэнэ.

8.2.2. МУБИС-ийн санхүүжилттэй төслийн үр дүнд бий болсон инновацын бүтээгдэхүүнээр оюуны өмчийн эрх авна.

8.2.3. Оюуны өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бий болно.

8.2.4. Оюуны өмч бүтээгч, зохиогч, эзэмшигч, ашиглагч, хэрэглэгчид эдийн болон эдийн бус баялгийн үр ашиг хүртэнэ.

8.2.5. Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулан, хуримтлал үүсэж, ашгийн зохистой хуваарилалт бий болно.

8.2.6. Хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээ нэмэгдэж, эдийн засгийн үр ашиг дээшилнэ.

8.2.7. МУБИС-ийн хөгжлийн дансанд хуримтлал бий болсноор багш, ажилтан, зочин судлаач, суралцагчдын цаашдын судалгаа-шинжилгээг дэмжих боломж бүрдэнэ.

8.2.8. Байгууллагын оюуны өмчийн соёл бүрэлдэнэ.

8.3. Бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

8.3.1. Оюуны өмчийн бодлогын хэрэгжилтийг Оюуны өмчийн хороо Эрдмийн Зөвлөлд тайлагнаж, чанарын баталгаажуулалт, мониторинг хариуцсан нэгж үнэлгээ хийнэ.

8.3.2. Бодлогын хэрэгжилтийг үнэлэхдээ Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн стратеги төлөвлөгөө (2025-2030)-ийн 8.3-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхээс гадна дараах шалгуур үзүүлэлтийг харгалзан үзнэ.

Бодлогын хэрэгжилтийн шалгуур, үзүүлэлт

	Шалгуур	2024	2025	2026	2027
1	МУБИС-ийн өмчлөлийн болон хамтран эзэмшигч, зохиогч нарын оюуны өмчийн эрхийн тоо	5	8	12	18
2	Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патентын тоо	0	1	1	2
3	МУБИС-ийн хамтран эзэмшиж буй оюуны өмчийн эрхийн тоо	0	0	1	1
4	Сургууль дээр байгуулсан гарааны компанийн тоо	1	1	1	2
5	МУБИС-д бүртгэлтэй оюуны өмчийн эрх авсан цахим хичээлийн тоо	4	6	9	14
6	МУБИС-д бүртгэлтэй оюуны өмчийн эрх авсан сургалт арга зүйн эмхэтгэл /мэргэжлийн хөтөлбөр/-ийн тоо	0	10	15	23
7	Оюуны өмчийн эрх бүхий бүтээгдэхүүний орлого/сая төгрөгөөр/	14	21	32	47
8	Оюуны өмчийн чиглэлээр зохион байгуулсан сургалт, семинар, хэлэлцүүлгийн тоо	2	3	5	8